

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 03 дугаар сарын 01-ээс 31-ний өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 1578 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 1307 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 271 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 210 гадаадын иргэнд хилийн боомтод, 4 иргэнд төвд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. Мөн 4 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
1307	271	214	416	832	0	130	79
1578							

03 дугаар сард нийт 626 аж ахуйн нэгж, байгууллагын 1377 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

“evisa.mn” цахим системээр нийт 26 улсын 222 иргэнд цахим виз олгож, 1 улсын 1 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 416 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 832 иргэний оршин суух зөвшөөрлийн

хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 266 иргэний бүртгэлд хасалт хийлээ. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 31 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 56 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 130 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 79 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 45,7 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 47,6 хувиар тус тус өсөж, виз олголт 72,1 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 21,2 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 852 ширхэг шинээр хэвлэж, 445 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 31 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 139 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 3 иргэнд регистрийн дугаар олгосон.

### 1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 2786 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
2426	178	22	138	22	2786

Код мессеж үйлчилгээг 281 иргэнд хүргэж, 20 гадаадын иргэнд паспорт, 999 иргэнд оршин суух үнэмлэхийг буцаан олголоо.

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 464, утсаар 579 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээ үзүүлжээ.

## 1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

### 1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар 19 иргэний хүсэлтийг хүлээн авч, 14 иргэн, 2 харьяалалгүй хүний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

#### Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
03 дугаар сар	-	-	-	15
2022 он /өссөн дүнгээр/	1	-	-	60

Түүнчлэн 7 иргэн, 1 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. (Хүснэгт 4)

Монгол Улсын харьяатаас гарч бусад улс (Бүгд Найрамдах Австри Улсын 1, Бүгд Найрамдах Казахстан Улсын 9, Бүгд Найрамдах Сингапур Улсын 5, Бүгд Найрамдах Солонгос Улсын 1)-ын харьяат болохоор 16 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

#### Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/д	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад Улс	3	-	1	-	-
	нийт	3	-	1	-	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	16	-	13	-	7
	нийт	16	-	13	-	7
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	2	-	1
	нийт	-	-	2	-	1

1994-2022 онд Монгол Улсын харьяат болсон 54 иргэний мэдээллийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэсэн.

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 3961 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 15 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 3)

### 1.2.2. Хүүхэд үрчлэлт:

Америкийн Нэгдсэн Улсын иргэн гэр бүлд үрчлэгдсэн 1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 1, нийт 2 хүүхдийн тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.

03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхэд үрчлэгдээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 2 байгууллагын хүсэлт, баримт бичигт холбогдох санал авах ажиллагааг явуулан, үйл ажиллагаа эрхэлж байгаа 1 байгууллагын үйл ажиллагааны тайланг хүлээн авсан.

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хүсэлт ирүүлсэн нийт 2 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлт (зөвшөөрлийн хугацааг сунгуулах 2)-ийг хэлэлцүүлж, шийдвэрлэв.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/485 дугаар, мөн сарын 28-ны өдрийн 01/589 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулаагүй.

Төлөвлөгөөт бус 27 удаагийн хяналт шалгалтаар 41 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 58 иргэнийг хамруулан, 1 зөрчлийг илрүүлж, Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан.

Хүснэгт 5а

Торгуулсан гадаадын иргэн						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-1.3	16.2-3.3		
1	Казахстан			1	1	2000,000
2	Вьетнам	1			1	100,000
3	Герман	1			1	100,000
4	Ирланд	1			1	100,000
5	Лаос	1			1	100,000
6	Өмнөд Солонгос	1			1	100,000
7	Сингапур	1			1	100,000
8	Турк	1			1	100,000
9	Хятад	6	1		7	700,000
	Нийт	13	1	1	15	3400,000

Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах журам, паспорт, паспортыг орлох баримт бичиг, эсхүл оршин суух үнэмлэхээ биедээ авч явах журам болон хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн нийт 9 улсын 15 гадаадын

иргэн, 1 уригч байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт зааснаар 3870,000 төгрөг (Гурван сая найман зуун далан мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5а, 5б, 6)

Хүснэгт 5б

Торгуулсан уригч аж ахуйн нэгж, байгууллага			
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл 16.2-4.2	Торгуулийн дүн
1	Вьетнам	1	470,000
	Нийт	1	470,000

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх зорилгоор 70133448 дугаар утасны үйлчилгээг ажиллуулж, иргэнээс ирүүлсэн 2 өргөдөл (дугаар 25, 29)-д холбогдох 2 улсын 3 иргэний асуудлыг шалгаж байна.

Хүснэгт 6

Зөрчлийн мэдээ (тухайн сард)							
Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
15	3300,000	1	1	470,000	-	-	-
Гадаадын иргэн							
Хуулийн үндэслэл	Шалтгаан			Торгуулийн хэмжээ (төгрөг)	Гадаадын иргэний тоо		
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн			1300,000	13		
Зөрчлийн тухай хууль 16.2-1.3	нутаг дэвсгэрт паспорт, паспортыг орлох баримт бичиг, эсхүл оршин суух үнэмлэхээ биедээ авч явах журам зөрчсөн			100,000	1		
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3	визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно			2000,000	1		
				3400,000	15		
Уригч аж ахуйн нэгж, байгууллага							
Хуулийн үндэслэл	Шалтгаан			Торгуулийн хэмжээ (төгрөг)	Уригч байгууллагын тоо		
Зөрчлийн тухай хууль 16.2-4.2	оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн			470,000	1		
				470,000	1		
	нийт			3870,000			

### 1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.4, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 4 улсын 6 иргэнийг байгууллагын даргын 6 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 7)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын

иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам"-ын 6.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Бүгд Найрамдах Казахстан Улсын 1 иргэнийг байгууллагын даргын тушаалаар Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгасан.


Хүснэгт 7

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сард)						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл				Нийт
		37.1.2	37.1.4	37.1.11	37.1.12	
1	Вьетнам	1				1
2	Казахстан				1	1
3	Орос		1	1		2
4	Өмнөд Солонгос			2		2
Бүгд		1	1	3	1	6

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 6 иргэнийг байгууллагын даргын 6 удаагийн тушаалаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэв.

Мөн дээрх үндэслэлээр хилээр гарахыг түдгэлзүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээлээ.

График 2



03 дугаар сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3,3 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 75,0 хувь өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн

этгээд 83,3 хувь, албадан гаргасан гадаадын иргэн 15,4 хувиар тус тус буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн 1 дүгээр улирлын танилцуулах мэдээг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/580 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгууллагын даргын 03 дугаар сарын 25-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулав.

Байгууллагын 02 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/454 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Монгол Улсад хөгжлийн шинэ загварыг бий болгох нь” сэдэвт хэлэлцүүлэгт байгууллагын тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн оролцов.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Төрийн захиргааны гүйцэтгэх 3 албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 03 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт хүргүүлж, сонгон шалгаруулалтын зарыг 03 дугаар сарын 16-аас 29-ний өдрүүдэд цахим системд байршууллаа.

Төрийн албаны тухай хууль тогтоомж, байгууллагын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын даргын 03 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д зааснаар албан хаагчдад төрийн захиргааны дэс түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгохтой холбогдох танилцуулгыг 03 дугаар сарын 23-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх салбар зөвлөлд хүргүүлэв.

Олон нийтийн сүлжээг ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлан таниулах, үнэн зөв мэдээ, мэдээллийг бодит эх сурвалжаас түгээх зорилгоор Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв”

фэйсбүүк пэйж хуудаст нэгдэх, дагах ажлыг зохион байгуулах чиглэлийг Захиргаа, удирдлагын газрын 03 дугаар сарын 28-ны өдрийн 03/47 дугаар дотоод албан бичгээр төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт хүргүүлсэн.

Байгууллагын даргын 03 дугаар сарын 28-ны өдрийн Б/86 дугаар тушаалаар Дорноговь аймаг дахь газар болон Өмнөд бүс, Хойд бүс, Зүүн бүс дэх газрын нийт 4 хяналтын улсын байцаагчийг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд Виз, зөвшөөрлийн газарт сэлгэн ажиллуулахаар шийдвэрлэв.

Төвийн зохион байгуулалтын нэгжүүдэд баримт бичгийн бүртгэл, хяналт хариуцсан орон тооны бус ажилтныг байгууллагын даргын 03 дугаар сарын 14-ний өдрийн А/43 дугаар тушаалаар шинэчлэн томилсон.

Албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний тайлангийн үнэлгээг харгалзан байгууллагын даргын 03 дугаар сарын 02-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар төв болон орон нутаг дахь газрын нийт 67 албан хаагчийн цалингийн шатлалыг, 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/83 дугаар тушаалаар 4 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоолоо.

Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 101 жилийн ой, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан Хууль зүйн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр 3, Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 4 нийт 7 албан хаагчид шагнал гардуулах ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан төрийн бус байгууллага хамтран “Тэгш боломж-хамтын үр дүн” уриан дор 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Төрийн захиргааны албан хаагч эмэгтэйчүүдийн анхдугаар чуулга уулзалт”-д 4 албан хаагч оролцсон.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах “Хаан шонхор 2022” нэгдсэн дадлага сургуулийн ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу “Хүн, агаарын хөлөг барьцаалсан террорист үйлдлийн үед сөрөг тусгай ажиллагаа явуулах террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх, “Тээврийн хэрэгсэл ашигласан болон тээврийн хэрэгслээр террорист халдлага үйлдсэн үеийн сөрөг тусгай ажиллагаа явуулах нь” сэдэвт дадлага сургуулилтад 03 дугаар сарын 09-өөс 12-ны өдрүүдэд, мөн Терроризмтой тэмцэх зөвлөлийн 1 дүгээр улирлын хуралдаанд 03 дугаар сарын 24-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дарга тус тус оролцов.

Дотоод хэргийн их сургуулийн харьяа Хилийн албаны сургуулиас 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан “Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын чадавхийг нэмэгдүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцож, Хойд бүс дэх газрын хяналтын улсын байцаагч Б.Хадбаатарын “Хилийн боомтын аюулгүй байдлыг хангахад эрх зүйн хэм хэмжээ” сэдвээр тавьсан илтгэл 3 дугаар байрт шалгарав.

“Цахим хөгжлийн багц хууль” сэдвээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан сургалтад нийт 30 албан хаагч хамрагдлаа.



Байгууллагын даргын 02 дугаар сарын 21-ний өдрийн 01-03/10 дугаар удирдамжаар “Шинээр томилогдсон албан хаагчийн чиглүүлэх сургалт”-ыг 02 дугаар сарын 28-аас 03 дугаар сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулж, төв, орон нутаг дахь нэгжийн нийт 10 албан хаагчийг хамруулсан.

Бритиш сургуультай хамтран “Хүүхдийн эрх”, “Боловсрол ба соёл”, Жендэрийн үндэсний хороотой хамтран “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, давхардсан тоогоор 206 албан хаагчийг танхим, цахим хосолсон хэлбэрээр тус тус хамрууллаа. Мөн Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ-аас 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан “Кибер аюулгүй байдал”, “Крипто валютын талаарх ерөнхий ойлголт” сэдэвт цахим сургалтад 50 албан хаагчийг оролцуулав.

### 2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 11 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 56 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (4 телевиз, 2 сонин, 50 сайт)-ээр сурталчилсан.

Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), elmmigration аппликэйшнд баяжилтыг хийж, байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээ авахтай холбоотой нийт 34 мэдээллийг байршууллаа.

03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “ Шинэ сэргэлтийн бодлого ба эрх зүйн орчны танилцуулга” уулзалт, зөвлөгөөний үйл ажиллагааг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулж, арга хэмжээний мэдээллийг 20 сайтад нийтлүүлэн, 14-ний өдөр Монголын үндэсний олон нийтийн телевизийн MNB World сувгаар англи хэлээр нэвтрүүлэв.

Түүнчлэн Evisa.mn цахим системийн үйл ажиллагаа, үйлчилгээ авах шат дарааллыг товч танилцуулсан 2 минут 42 секундийн видео шторкийг англи, монгол хэлээр 4 сайтад байршуулж, фэйсбүүкийн 75 группэд түгээсэн.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

### 2.2.1. Хууль, эрх зүй:

“Гадаадын иргэний оршин суух бүртгэл, хяналтын программ хангамжийн нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлтийн ажлын талаар холбогдох арга хэмжээ авах, хамтран ажиллах тухай албан бичгийг 03 дугаар сарын 14-ний өдөр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлжээ.

Гадаадын иргэн, харьяатын газарт холбогдуулан нэг иргэний нэхэмжлэлтэй захиргааны хэргийг шийдвэрлэсэн Захиргааны хэргийн анхан шатны шүүгчид холбогдуулан гаргасан гомдлыг 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/552 дугаар албан бичгээр Шүүхийн сахилгын хороонд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт хуулийн мэргэжилтэн оролцлоо.

### 2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга Тайбэйн Худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын тэргүүнийг 03 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авч уулзан харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Монгол Улсын иргэд олноор оршин суудаг орнуудын гадаадын иргэн, харьяат, цагаачлалын байгууллагуудтай холбоо тогтоож, хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Цагаачлалын байгууллагатай хамтран ажиллах тухай “Санамж бичиг”-ийн төслийг боловсруулан Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа ЭСЯ-д санал авахаар хүргүүлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан “Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тулгамдаж буй асуудал, шинэчлэх шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хэсэгт Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, гадаад харилцааны мэргэжилтэн ажиллав.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын консулын асуудал эрхэлсэн албан хаагчдад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагаа, шинээр нэвтэрсэн үйлчилгээг танилцуулах, мэдээ мэдээллээр хангах зорилгоор 03 дугаар сарын 11-ний өдөр “Шинэ сэргэлтийн бодлого ба эрх зүйн орчны танилцуулга” уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан.

“Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Киргиз Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны гэрээ”-ний төсөлд тусгах саналыг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/588 дугаар албан бичгээр хүргүүлээ.

“Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулахтай холбогдуулан албан айлчлал хийх тухай 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/540 дүгээр албан бичгийг Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын НАХЯ-ны харьяа Цагаачлалын албанд хүргүүлэв.

Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай 03 дугаар сарын 24-ний өдрийн 01/581 дүгээр албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Мөн Бүгд Найрамдах Турк Улсын Шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан айлчлал хийхтэй холбогдуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг хүссэн 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/582 дугаар албан бичгийг ТИКА-гийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулах газарт хүргүүлээ.

Америкийн Нэгдсэн Улсын төрийн департаментийн Экспортыг хянах болон хилийн аюулгүй байдал (EXBS)-ын хөтөлбөрийн санхүүжилтээр Нью Йорк мужийн Албанигийн их сургуулийн Бодлогын судалгааны төвөөс 03 дугаар сарын 23-ны өдөр “НҮБ-ын зүгээс Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын эсрэг авсан хориг арга хэмжээ, түүнийг зөрчиж буй аргууд, тэдгээрийг таних, таслан зогсоох” талаар зохион байгуулсан сургалтад Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга оролцлоо.

Гадаад харилцааны яамнаас 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан Монгол Улсад НҮБ-аас 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичгийн хэрэгжилтэд оролцох НҮБ-ын системийн байгууллага болон Монгол Улсын хэрэгжүүлэгч төрийн байгууллагын талаарх

танилцуулга, арга хэмжээнд Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга оролцлоо.

Мөн өдөр НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас зохион байгуулсан "Эрүүл мэндийн болон вакцины гэрчилгээ, Шинэ төрлийн хуурамч бичиг баримттай хэрхэн тэмцэх вэ?" сэдэвт сургалтад гадаад харилцааны мэргэжилтэн хамрагдав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан "Аялал жуулчлалын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь" цуврал хэлэлцүүлэгт Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга оролцсон.

### 2.3.2. Дотоод хяналт:

Тайлант хугацаанд байгууллагын даргын А/78 дугаар тушаалаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын 4.3 дахь заалтыг үндэслэн төлөвлөгөөт бус 6 удаагийн шалгалтыг явуулж, тухайн зөрчилтэй холбоотой шалгалтын материал, дүгнэлт, саналыг холбогдох албан тушаалтанд танилцуулан, шийдвэрлүүлээ.

"Эрүүл-аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага шалгаруулах журам"-ын дагуу нэгдүгээр шатны шалгаруулалтад холбогдох баримт бичгийг 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/450 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын хэмжээнд "Immigration talent show-2022" урлагийн наадмыг 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 02 дугаар зөвлөмжийг төв орон нутгийн нэгжийн дарга нарт хүргүүлэв.

ХӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын багаас ирүүлсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын 497, 498, 499, 500 дугаар мэдээг зохион байгуулалтын нэгжүүдэд цахимаар хүргүүлсэн.

## 2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

### 2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Архивд баримт хүлээн авах хуваарийн дагуу 2021 оны баримтуудыг файлаар болон DVD (1 ширхэг) хэлбэрээр, мөн зохион байгуулалтын нэгжүүдээс бүртгэлийн дагуу нийт 167 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийлээ.

Хууль тогтоомжийн хүрээнд 9 албан хаагчид 27 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 18 албан хаагчид 159 хуудас баримтыг "Хуулбар үнэн" тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтлөв.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 25, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 23 буюу нийт 48 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 155 албан бичиг (*хариутай 75*)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, нийт 159 албан бичгийг гадагш илгээсэн ба хяналтад 27 албан бичиг байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн албан бичиг бүртгэгдээгүй.

#### 2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчаас төв байгууллагад 22 (*иргэнээс 8, албан хаагчаас 14*), боомт, орон нутаг дахь нэгжид 22 (*иргэнээс 6, албан хаагчаас 16*) өргөдөл буюу нийт 44 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 34 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 10 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөлгүй.

#### 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

##### 2.5.1. Программ хангамж:

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-ээр дамжуулан Монгол Улсын хилээр 02 дугаар сард нэвтэрсэн 1741 гадаадын иргэнд регистрийн дугаар олгосон.

Байгууллагын цахим сайт, Eimmigration.mn сайтад төлбөрийн нэхэмжлэл үүсгэх программ хангамжийг нэмэлтээр хөгжүүлж, ажиллагаанд бэлтгэж байна.

ISM системд хэрэглэгчийн 12 эрхийг шилжүүлэн сольж, мэдээллийн сангийн хуулбарыг 03 дугаар сарын 18-ны өдөр архивласан.

Байгууллагын цахим сайтын нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд “Виз” цэс дэх Монгол Улсад байх хугацаа сунгах хүсэлт гаргах хэсгийн мэдээлэл, “Визийн зөвшөөрөл” цэс дэх “Албан” ангиллын мэдээллийг засварлаж, Солонгос хэл дээрх орчуулгыг өөрчилж, засварлалаа.

Визийн мэдээллийн нэгдсэн сан “Eviza.mn”-ийн хөгжүүлэлтийн хүрээнд уригчийн модуль, Худалдаа хөгжлийн банкны төлбөрийн системийг нэвтрүүлэхээр ажиллаж, банктай байгуулах гэрээний төслийг боловсруулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан шийдвэрийн дагуу төлбөрийн нөхцөлийг тодорхойлсноор уригчийн модулийн хэсгийг нэвтрүүлэхээр хүлээгдэж байна.

Чингис хаан Олон улсын нисэх буудалд 03 дугаар сарын 28-ны өдөр ажиллаж, Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын нэгдсэн BOREX системтэй танилцсан.

#### 2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

##### 2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

03 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 2,990.3 сая төгрөгийн санхүүжилт авч 1,586.6 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 04 дүгээр сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/579 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8 дахь хэсэгт заасан хилийн боомт, орон нутаг дахь албанд 5-аас доошгүй жил ажиллаж байгаа ажилтанд олгох ажилласан 5 жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг байгууллагын даргын 2022 оны Б/52, Б/53, Б/54, Б/55 дугаар тушаалаар нийт 4 албан хаагчийн дансанд шилжүүлсэн байна.

Монгол улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа ЭСЯ, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа ерөнхий консулын газарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн 2022 оны урсгал зардлын 3 дугаар сарын санхүүжилтийг тухайн газруудад шилжүүлсэн.

Төсвийн шууд захирагч нарын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тухайн орон нутгийн харьяа Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар нэгжүүд “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилласан. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/457 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт, 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/578 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн тайлбарыг 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/594 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад төсөв санхүүгийн 65 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 65 мэдээ, бусад 91 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан байна.

#### 2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдөр дуустал (өссөн дүнгээр) 175.0 сая төгрөгийн орлого, 1305124929 тоот валютын дансанд мөн хугацааны өссөн дүнгээр 5183.27 ам.доллар буюу 14.9 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлээд байна.

#### 2.6.3. Худалдан авалт:

Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын гэрээг баталгаажуулан 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/595 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мэдээлэл технологийн үйлчилгээний багц 1, 2 дугаарт Аверс секьюрити ХХК-аас Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газарт гомдол гаргаснаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан холбогдох материалуудыг 03 дугаар сарын 23-ны өдрийн 01/565 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүллээ.

### 2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

#### 2.7.1. Хяналт-шинжилгээ:

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 02 дугаар сарын статистик мэдээг 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 02 дугаар сарын үйл ажиллагааны мэдээг мөн өдрийн 01/470, 01/471, 01/472 дугаар албан бичгээр Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж ажилласан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журмууд шинэчлэн батлагдсантай холбогдуулан статистик мэдээлэл, судалгааны маягтад өөрчлөлт оруулах саналыг 03 дугаар сарын 15-ны өдрийн 3/514 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус байгууллагатай холбогдох арга хэмжээний хэрэгжилт болон байгууллагын даргын 2021 онд баталсан тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг тус тус илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулсан.

#### 2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Байгууллагын даргын 02 дугаар сарын 08-ны өдрийн “Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх тухай” 10/02 дугаар удирдамжаар хийсэн аудитын тайланг 03 дугаар сарын 09-ний өдрийн 01-10/04 дүгээр илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан, зөвлөмж гаргалаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудаст байршуулсан 02 дугаар сарын мэдээлэлд хяналт тавьж ажиллав.

#### 2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Тайлант хугацаанд орон нутаг дахь нэгжүүдийн дарга нараас 17 тушаал (*үндсэн үйл ажиллагаатай холбоотой 10, хүний нөөцтэй холбоотой 7*) баталсныг бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг тооцон ажиллалаа.

Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчаас тус бүсэд хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх барилга байгууламжийн инженерийн зураг, ажлын даалгаварт тусгах саналыг 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/448 дугаар албан бичгээр, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчид чөлөөт бүсийн гүний гарцын хяналт шалгалтын цогцолборын зургийн даалгаварт тусгах саналыг 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/462 дугаар албан бичгээр, Ховд агаарын замын боомтод үйлдэгдэх олон улсын нислэгийн бэлэн байдлыг хангаж ажилласан танилцуулгыг 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/616 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Орон нутаг дахь нэгжүүд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу хууль, эрх зүй болон хувь хүний хөгжил, харилцааны чиглэлээр дотооддоо нийт 10 удаагийн сургалт, Зүүн бүс дэх газар 7 хоног тутмын “Монгол бичгийн хичээл”-ийг тус тус зохион байгуулсан байна.

Мөн төрийн бусад байгууллагуудаас хууль эрх зүй, хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн чиглэлээр зохион байгуулсан нийт 17 удаагийн сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 186 албан хаагч хамрагджээ.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Сангийн яамнаас хэрэгжүүлж буй "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн хүрээнд Алтанбулаг хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлийн барилга угсралтын ажил эхэлснээр, Алтанбулаг боомтын цогцолборт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд 03 дугаар сарын 01-ний өдөр барилгыг чөлөөлж, чөлөөт бүсийн баримт бичиг шалгалтын байранд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

Ховд олон улсын нисэх буудалд Хүннү Эйр компани Улаанбаатар-Ховд-Нурсултан болон буцах чиглэлд олон улсын нислэг үйлдэж эхлэхтэй холбоотойгоор Баруун бүс дэх газар нь Хилийн 0130 дугаар анги, Ховд олон улсын нисэх буудлын захиргаа, Булган боомт дахь гаалийн газартай хамтран хилийн боомтод ажиллах журмыг хэлэлцэн баталж, боомтын зөвлөлийг байгуулав. Дээрх ажлын хүрээнд Ховд нисэх буудлаас Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК чиглэлтэй антенуудыг байрлуулж, түр сүлжээ үүсгэн, гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISM) болон дотоод сүлжээний программуудыг суулгаснаар нислэг хүлээж авах бэлэн байдалд шилжүүлээ.

Япон Улсын Засгийн газраас иргэдээ Оросын Холбооны Улсад зорчихгүй байх, оршин суугаа иргэдийг тухайн улсаас гарах зөвлөмж гаргаснаар Япон Улсын иргэд Алтанбулаг хилийн боомтоор нэвтэрч Монгол Улсаар дамжин нутаг буцах тохиолдолд "Иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээр"-ийн дагуу саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллах тухай хүсэлтийг Япон Улсын ЭСЯ-аас Монгол Улсын Гадаад харилцааны яаманд ирүүлсэн. Энэ арга хэмжээний хүрээнд байгууллагын дарга 03 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд Хойд бүс дэх газарт ажиллаж, Япон Улсын ЭСЯ-ны дэд консултай уулзалт зохион байгуулав.

"Чингис хаан" нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний "Барилга байгууламжийг тэсрэх хэрэгслээр заналхийлэх үйлдэл (код-7)" сэдвээр 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан ширээний дасгал сургуулилтад Агаарын замын боомт хариуцсан газрын хяналтын улсын байцаагчид оролцсон.